

МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭ АШИГЛАХ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ ШААРДЛАГА

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү баримт бичгээр мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргагчид болон энэхүү тусгай зөвшөөрлийг эзэмшигчдэд тавигдах тусгай нөхцөл шаардлагуудыг тодорхойлно.

1.2. Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын хууль тогтоомж, бодлого, шийдвэр, Монгол Улсын үндэсний стандарт, норматив баримт бичиг, болон Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх)-ноос баталсан журам, нөхцөл, шаардлага, “Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх зохицуулалтын журам” болон энэхүү баримт бичгийн хүрээнд гаргасан Зохицуулах хорооны холбогдох шийдвэрийг дагаж мөрдөнө.

1.3. Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэхээр өргөдөл гаргагч нь харилцаа холбооны үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байна.

1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь “Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх зохицуулалтын журам”-ын 3 дугаар зүйл заасан мэдээллийн сүлжээний нээлттэй байдлыг бүрэн хангаж ажиллана.

1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь “Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх зохицуулалтын журам”-ын 4 дүгээр зүйлд заасан нийтлэг шаардлагыг хангаж ажиллахыг өөрийн үйлчилгээний хэрэглэгчдийн гэрээнд тусгасан байна.

1.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэв цахилгаан холбооны сүлжээтэй холболт хийж мессежний үйлчилгээ эрхлэх бол Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчөөгүй эсэхэд хяналт тавьдаг байна.

1.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь “Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль”, “Кибер аюулгүй байдлын тухай хууль” болон эдгээр хуульд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартыг үйл ажиллагаандаа дагаж мөрддөг байна.

1.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэхтэй холбоотой техник, тоног төхөөрөмжийн суурилуулалт, ашиглалт үйлчилгээ, тухай чиглэлийн үйлчилгээний талаар мэдлэг туршлага бүхий мэргэжлийн хүний нөөцтэй байна.

1.9. Өргөдөл гаргагч нь тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргахдаа ирүүлсэн мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эхлүүлэх болон үйл ажиллагааны төлөвлөгөөгөө баримтална. Уг төлөвлөгөө нь явцын дунд өөрчлөгдөж болох бөгөөд хэрэв өөрчлөгдсөн тохиолдолд Зохицуулах хороонд тухай бүр албан бичгээр мэдэгдэнэ.

1.10. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчдэд үйлчилгээ, үнийн ялгавартай бодлого барихгүй байх үүрэгтэй.

2. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ШААРДЛАГА

2.1. Техник тоног төхөөрөмжүүд нь Зохицуулах хорооноос зөвшөөрөгдсөн олон улсын лаборатори, байгууллагын баталгаажуулалтын гэрчилгээтэй байна.

2.2. Хэрэв цахилгаан холбооны сүлжээтэй харилцан холболт хийсэн тохиолдолд дараах техникийн нөхцөл шаардлагыг хангаж ажиллана.

2.2.1. үүрэн холбооны оператор компанитай SSL сертификаттай протокол ашигласан холболт хийсэн байна.

2.2.2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах боломжийг бүрдүүлэх үүднээс үүрэн холбооны оператор компанитай тусгай (dedicated) шилэн кабелийн шугамаар холбогдох шаардлагатай бөгөөд хамгаалалт хангасан протокол ашигласан байх ёстой.

2.2.3 VPN холболт үүсэх боломж бүхий нууцлалын (Firewall) төхөөрөмжтэй байна.

2.2.4. Системийн хэт ачааллаас хамгаалах үүднээс үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч рүү хандах интерфэйсийн хувьд ачааллын хязгаарлалт тавьдаг боломжтой байх ба ачаалал даах чадварын хэмжээг баталгаажуулсан байна.

2.2.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн систем нь өөрийн гэсэн хяналтын програмтай байх ёстой бөгөөд гэмтэл гарсан үед SNMP протокол ашиглан шаардлагатай дохиоллыг үйлчилгээ эрхлэгчид мэдээлдэг байна.

2.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь “Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх зохицуулалтын журам”-ын 5 дугаар зүйлд заасан арга хэмжээг нэн даруй авах техникийн боломж, нөхцөлийг хангасан байна.

2.4. Найдвартай ажиллагааг бүрэн хангах үүднээс найдвартай ажиллагааны төвшинг 99 хувиас дээш хангаж ажиллана.

2.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлчилгээний найдвартай ажиллагааг хангах зорилгоор сүлжээний удирдлага, хяналтын нэгдсэн системтэй байна.

2.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлчилгээний чанар, стандарт болон норматив шаардлагыг ханган ажиллах зорилгын хүрээнд техник, тоног төхөөрөмжид байнгын хэмжилт, тогтмол хяналт хийх хэмжүүрийн багаж, хэрэгсэл эсхүл программ хангамжаар хангагдсан байна.

3. ХОЛБОЛТ

3.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь бусад харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээтэй харилцан холболт хийхийн өмөн урьдчилан туршилт хийж, протокол үйлдэн хувийг Зохицуулах хороонд ирүүлнэ.

3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн хэрэглэгчдэд тавигдах гэрээ, нөхцөл шаардлагыг боловсруулж, Зохицуулах хороогоор хянуулна. Уг нөхцөл шаардлага нь үйл ялгаварласан, ойлгомжтой, тодорхой байх шаардлагуудыг хангасан байна.

3.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг нийтлэг нөхцөл шаардлагыг тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор Зохицуулах хороонд ирүүлнэ.

3.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлчилгээ эрхлэгчтэй харилцан холболтын тооцоо хийхэд шаардлагатай статистик, тайлан мэдээг гаргадаг системтэй байна.

3.5. Зохицуулах хорооноос шаардсан өөрийн үйлчилгээтэй холбоотой шаардлагатай статистик мэдээллүүдийг хагас жил тутам гаргаж заасан хугацаанд ирүүлнэ.

4. ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 4.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн үйлчилгээ бүрийн тайлбар, ангилал, хэрхэн хандаж үйлчилгээ авах, үйлчилгээний төлбөрийг үнэн зөв ойлгомжтойгоор хэрэглэгчдэд мэдээлдэг байна.
- 4.2. Энэхүү нөхцөл шаардлагын 2.5-д дурдсан хяналтын нэгдсэн системийн мэдээллийг 6 сараас доошгүй хугацаагаар архивлан хадгална.
- 4.3. Техник, тоног төхөөрөмж шинээр суурилуулах, өргөтгөх, шилжүүлэх, технологийн шинэчлэл нь хэрэглэгчийн үйлчилгээнд сөргөөр нөлөөлөхөөр бол авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Зохицуулах хороо болон хэрэглэгчдэд урьдчилан мэдээлнэ.
- 4.4. Үндсэн сервер, төхөөрөмжүүдийн кибер халдлагаас хамгаалах, хэрхэн хамгаалагдаж байгаа талаар үзлэг шалгалтыг батлагдсан хуваарийн дагуу тогтмол хийж, протокол тэмдэглэл хөтөлдөг байна. Кибер халдлагын талаарх мэдээллүүдийг ангилж хагас жил тутам Зохицуулах хороонд хүргүүлнэ.
- 4.5. Зохицуулах хорооноос тогтоосон үйлчилгээний чанарыг хангаж ажиллах ба тэдгээрийг хянах техникийн боломжийг бүрдүүлсэн байна.
- 4.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлчилгээ эрхлэгчтэй Зохицуулах хорооноос гаргасан загварын дагуу SLA(Service Level Agreement) гэрээ байгуулсан байна.
- 4.8. Хэрэглэгчээс интернэтийн үйлчилгээтэй холбоотой гомдол, санал (вэбсайтаар дамжуулан) хүлээж авах, шийдвэрлэх журамтай байх ба гомдол маргааныг үл ялгаварлах, шуурхай байдлаар шийдвэрлэнэ.
- 4.9. Хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа хэрэглэгчийн эрх ашгийг зөрчихгүй, хэт нэг талыг барихгүй, эрх тэгш, шударга байх зарчмыг баримтална.
- 4.10. Холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу Зохицуулах хорооноос мэдэгдсэн Монгол Улсын хууль зөрчсөн веб сайт, контент, аппликэйшнийг хандалтыг хязгаарладаг байх;
- 4.11. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас үйлчилгээ үзүүлэх боломжгүй болох, тусгай зөвшөөрөл нь дуусгавар болох, хүчингүй болох эсвэл дампуурах тохиолдолд хэрэглэгчийг хохироохгүй байх арга хэмжээг авах, энэ талаар үйлчилгээний журам, нөхцөл шаардлагадаа заавал тусгасан байна.